



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/49

Хархорин сум

**Төрийн албан хаагчдын цалинг
шинэчлэн батлах тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1, 57.2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 1, 4 дүгээр хавсралт болон 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2.1, 2.3 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 3, 12 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчдын цалинг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Батлагдсан цалингийн санд багтаан албан хаагчдын цалинг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бодож олгохыг нягтлан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2025 оны А/04 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

